

ТАТВАР БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс • Дугаар 04/2020 • 2020 оны 4-р сар

Ковид-19 цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай

Холбогдох хаяг:

Майк Ахэрн

Партнер, Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
michael.ahern@kz.pwc.com

Чойжамцын Цэндмаа

Гүйцэтгэх захирал, Татвар, Хуулийн
зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@mn.pwc.com

Марина Тарнавска

Ахлах Менежер, Татвар, Хуулийн
зөвлөх үйлчилгээ
tarnavska.maryna@mn.pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн Ахлах Зөвлөх
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Прайсуотерхаускүперс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол Улс
Утас: + 976 70009089
Факс: +976 11 322068

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2020 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC.

All rights reserved. In this document, "PwC" refers to

PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.



2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Монгол Улсын Их Хурлын ("УИХ" гэх) нэгдсэн чуулганаар Ковид-19 цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай УИХ-н тогтоол болон дараах хуулиудыг баталсан. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай
- Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай
- Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай
- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай
- Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай.

Эдгээр эдийн засгийг идэвхижүүлэх багц хуулиуд болон УИХ-ын тогтоол нь хувь хүн, байгууллага, хуулийн этгээдүүдэд ямар үр дагавар, нөлөө үүсгэхийг дараах байдлаар тоймлон танилцуулж байна. Үүнд:

1. **Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх.** Цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагч Монгол улсын иргэнд олгосон цалин, хөдөлмөрийн хөлсөнд хамаарах нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүргээс 6 сарын хугацаанд чөлөөлөхөөр болсон (2020 оны 4 сарын 1-нээс 2020 оны 10 дугаар сарын 1-нийг хүртэл). Мөн тодорхой тэтгэмжийг даатгуулагчид 3 сар олгохоор заажээ.

Даатгуулагч Монгол Улсын иргэнд олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагчийн төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу төлснөөр тооцохоор болсон.

ТАТВАР БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс • Дугаар 04/2020 • 2020 оны 4-р сар

Энэхүү чөлөөлтөд дараах этгээдүүд/нөхцөлүүд хамаарахгүй:

- Төрийн байгууллага, төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсний төлбөрөөс цалин хөлс авч нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөх даатгуулагчид.
- 2020.03.25-ны өдрөөс хойш нийгмийн даатгалын байгууллагад шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн хуулийн этгээд, сайн дураар даатгуулсан даатгуулагчид.

Харин, “эрүүл мэндийн даатгал”-ын шимтгэл төлөлт чөлөөлөгдөөгүй тул даатгуулагчийн болон ажил олгогчийн цалин хөлснөөс сар бүр 2% иар төлөх үүрэг нь хэвээр үлдэж байна.

Даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020.04.01-ний өдрөөс 2020.07.01-ний өдөр хүртэлх 3 сарын хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.000 төгрөгийн тэтгэмж олгоно:

- Энэхүү тэтгэмжийг төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн ажилтнуудад олгоно. Эрх бүхий аж ахуйн нэгжүүд нь Ковид-19 цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж байгаа гэдгээ нотлох шаардлагатай.
- Нарийвчилсан журмыг Засгийн газар батална.

- 2. Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх.** Монгол Улсын иргэний 2020.04.01-ний өдрөөс 2020.10.01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлнө.

Хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан журмыг Татварын Ерөнхий газар батлана.

- 3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх.**

АНОАТТХ-ийн тухай хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгч хуулийн этгээдийн ийн 2020.04.01-ний өдрөөс 2020.10.01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон орлогод мөн хуулийн 20.1, 20.2.7-д заасны дагуу ногдуулан тайлагнасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг чөлөөлнө.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэх тендерт шалгарч, тус ажлыг хийж гүйцэтгэж байгаа албан татвар төлөгчийн хувьд уг ажилтай холбоотой олсон орлогод дээрх чөлөөлөлт хамаарахгүй. Мөн албан татвар төлөгч энэ хуульд заасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахгүй байх эрхтэй.

Тус чөлөөлөлт, хөнгөлөлттэй холбоотой нарийвчилсан журмыг Татварын Ерөнхий Газар батална.

- 4. Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх.** Ковид-19 цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж ирж буй байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөөр заасан байна.

Барааны жагсаалтыг Засгийн газар батална.

- 4. Торгууль, холбогдох алдиангиас нэг удаа чөлөөлөх.**

Татвар төлөгчийн 2020.02.01-ний өдрөөс 09.01-ний өдрийг хүртэлх хугацаанд хуулийн дагуу тайлагнасан бөгөөд төлбөл зохих татварыг төлөөгүй тохиолдолд ногдуулах торгууль, алдангиас нэг удаа чөлөөлнө.

2020.02.01-ний өдрөөс 04.01-ний өдрийг хүртэлх хугацаанд тайлагнасан боловч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй хуулийн этгээдийг холбогдох торгууль, алдангиас нэг удаа чөлөөлнө.

Дээр дурдсан чөлөөлөлт болон бусад арга хэмжээтэй холбоотой асууж тодруулах зүйл байвал бидэнтэй холбогдоно уу.

TAX AND LEGAL ALERT

Mongolia • Issue 04/2020 • April 2020

Stimulus package for protecting public health, retaining workplaces and stimulating the economy during COVID-19 Pandemic

Contacts:

Michael Ahern

Partner & TLS Leader
michael.ahern@pwc.com

Tsendmaa Choijamts

Executive Director, Tax and Legal Services
tsendmaa.choijamts@pwc.com

Maryna Tarnavska

Senior Manager, Tax and Legal Services
tarnavska.maryna@pwc.com

Munkhjargal Ragchaakhuu

Senior Legal Consultant
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

PwC Tax TMZ LLC

Central Tower 6th floor
Suite 603, Ulaanbaatar
14200, Mongolia
Tel : + 976 70009089
Fax : +976 11 322068

www.pwc.com/mn

This Alert is produced by PwC Tax TMZ LLC. The material contained in this alert is provided for general information purposes only and does not contain a comprehensive analysis of each item described. Before taking (or not taking) any action, readers should seek professional advice specific to their situation. No liability is accepted for acts or omissions taken in reliance upon the contents of this alert.

© 2020 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC.
All rights reserved. In this document, "PwC" refers to PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.



On 9 April 2020, the Parliament adopted a resolution and the following laws were promulgated in response to the COVID-19 pandemic, for the purpose of protecting the public health, safeguarding the employments and stimulating the economy:

- *Law on Corporate Income Tax Exemptions and Tax Credits*
- *Law on waiver from Tax Penalties and Fines*
- *Law on Exemption from Personal Income Tax*
- *Law on Exemption from Customs Duty*
- *Law on Exemption from Value Added Tax*
- *Law on Exemptions from Social Insurance contributions and Support from the Unemployment Insurance Fund*
- *Law on waiver of Penalties and Fines on Employer contribution Social Insurance.*

Below is an overview of the Government's key measures to stimulate the economy and providing relief to individuals, legal entities and organizations impacted adversely by the Covid-19 pandemic:

- 1. Exemption from social insurance contribution to employees and employers and providing allowance to employees out of the Unemployment Insurance Fund.** Social insurance contribution by employers and by employees of Mongolian citizen who work at legal entities, which protect job of its employees despite decrease in their revenues due to the impact of COVID-19, will be exempt from payments of such contribution for period of 6 months (from 1 April 2020 to 1 October 2020). Further employees will be provided with allowances for 3 months.

For employees of those legal entities, it will be construed, that all such social insurance contribution in relation to pension, unemployment insurance and industrial accident insurance, levied on wages and similar income shall be deemed to be as paid for all purpose of the social contribution law.

TAX AND LEGAL ALERT

Mongolia • Issue 04/2020 • April 2020

The said exemption is not applicable to the following persons/cases:

- For insured persons working in state organizations, legal entities with wholly or partially owned by state or local government, excluding the state owned universities and colleges as well as those whose salaries being paid for the performance of contracts which are funded by loans or grants from foreign countries or international organizations.
- For private businesses, organizations and voluntarily insured persons who are newly registered under the social insurance schemes of the Government, on or after 25 March, 2020.

However, “health insurance” premiums are not subject to the above exemption, and they are continued to be levied and paid at the rate of 2% of the salary, as same as before.

During the period from 1 April 2020 to 1 July 2020, a monthly allowance of MNT 200,000 will be provided to insured persons-Mongolian nationals for 3 months out of the Unemployment insurance fund:

- The allowance will be provided to employees of legal entities, excluding legal entities which are state or local government owned or entities with a state ownership participation. Eligible entities must prove that their operation was suspended by the decision of the state authorities in response to the COVID-19 outbreak and they should continue to maintain the employees headcount in spite of the decrease in their revenues during February and March 2020 by 50% or more as compared to the same period of the previous year.

- The Cabinet will adopt a detailed regulation in this regard.

2. Personal income tax exemption will apply on salaries, wages, bonuses, incentives and similar employment remuneration earned by Mongolian nationals from 1 April 2020 to 1 October 2020.

- The General Tax Authority will adopt a detailed regulation in this regard.

3. Corporate income tax exemption

Income of resident taxpayers, whose taxable income specified under Articles 18.2, 18.3, 18.4 and 18.5 of the Corporate Income Tax Law were less than MNT 1.5 billion in the previous tax year and who duly reported and were regular in payment of their obligations in accordance with Article 20.1 and 20.2.7 of the same Law, shall be exempted from corporate income tax from 1 April 2020 to 1 October 2020.

This exemption is not applicable to taxpayers which are owned by state or local government authorities or by those entities which generates income from business which are awarded by public tenders or which are funded by loans or grants by foreign countries or international organizations. Further taxpayers can opt not to claim benefit under this Law on CIT exemption.

The General Tax Authority will adopt a detailed regulation in this regard.

4. Exemption from custom duty and a value added tax for the import of diagnostic kits, drugs, medical devices, equipment, disinfectants and face masks for the purpose of treatment or diagnostic of the COVID-19.

The Government shall approve the list of applicable products.

5. Waiver of penalties and late payment interests

If taxpayers fail to pay the taxes during the period from 1 February to 1 September 2020, the applicable penalties and late payment interests will be waived off.

If legal entities, which submitted social and health insurance reports during 1 February to 1 April 2020, fails to pay the applicable social insurance contributions, the applicable penalties and late payment interests will be waived off.

Should you have further inquiries and question in relation to the mentioned exemptions and other measures, please do not hesitate to contact us.